

Н.ГАНТУЛГА

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн сургуулийн
захирал, хууль зүйн доктор,
дэд профессор, хурандаа

КАНАД УЛС ДАХЬ НИЙГМЭЭС
ТУСГААРЛАХТАЙ ХОЛБОГДОЛГҮЙ
ЭРҮҮГИЙН ЯЛЫН ТӨРЛҮҮД

Манай улсад өрнөж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд эрүүгийн ялын бодлого, төрөл, агуулгыг шинээр тодорхойлж ялын тогтолцоон дахь нийгмээс тусгаарлахтай холбогдолгүй ялын¹ төрлийг нэмэгдүүлэх асуудлаар нарийвчилсан судалгааны ажил хийгдэж буй энэ цаг үед өөрийн олсон мэдээллийг нийгэмд хүргэх зорилгоор энэхүү өгүүллийг бичлээ.

Хорих ялтай харьцуулахад гэмт хэрэг үйлдэгсдийг нийгэмшүүлэх зорилгод илүү нийцсэн, хүмүүнлэг, эдийн засгийн хувьд үр ашигтай байх зэрэг нийгмийн зайлшгүй шаардлагыг хүлээн зөвшөөрсний үр дүн болон Канад улсад (цаашид “Канад” гэх) пробацийн тогтолцоо² бүрэлдэн тогтжээ.

Энэ улсын эрүүгийн хуульд 1921 онд өөрчлөлт орж шүүхийн офицер пробацийн гүйцэтгэлд хяналт тавих болж улмаар засаг захиргааны нэгжүүдэд пробацийн албад байгуулагдсан.

Өнөөгийн Канадын эрүүгийн хуульд тодорхойлсноор гэмт хэрэг үйлдэгчдэд хүлээлгэх эрүүгийн аливаа санц (ял) нь дараах зорилгод нийцсэн байх ёстой. Энэ нь:

- гэмт этгээдийн эрх зүйн эсрэг чиглэсэн зан үйлийг буруушаан зэмлэх;
- нийгмийг хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийтлэг зорилгод нийцсэн байх;
- зайлшгүй шаардлагатай үед гэмт хэрэгтнийг нийгмээс тусгаарлах;
- гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх³ (буруу зан үйл, амьдралын хэвилийг нь өөрчлөх);
- бусдад учруулсан гэм хорыг арилгуулах, нөхөн төлүүлэх явдлыг хангах;
- гэмт хэрэг үйлдсэн этгээдээс хариуцлагаа хүлээн зөвшөөрөх (ухамсарлах) мэдрэмж-зан төлөвийг төлөвшүүлэх явдал тус тус болно.

Мөн гэмт хэрэгтэнд оногдуулж буй ял нь нэг талаас тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюулын түвшинд нийцсэн, нөгөө талаас ялтныг аль болох нийгмээс тусгаарлахтай холбогдолгүй байх ёстой.

Канадын эрүүгийн хуульд тусгасан ялын төрөл нь:

- пробаци
- торгууль
- эд хөрөнгө хураах
- гэмт хэргийн хохирогчид татвар төлөх
- реституци (гэмт хэрэгтний хууль бусаар авсан эд зүйлсийг эзэнд нь эргүүлэн өгөх, хохирлыг арилгах)
- хорих ялыг тэнсэн харгалзах
- хорих тус тус болно.

2011-2012 онд Канадын шүүхээс гэмт этгээдэд оногдуулсан ялын 45%-ийг пробаци, 35%-ийг хорих ял эзэлжээ⁴.

¹ Хорихоос өөр төрлийн ял хэмээн манай улсад ярьж хэвшсэн.

² Хорихоос өөр төрлийн буюу нийгмээс тусгаарлахтай холбогдолгүй ялын хэрэгжилтийг ханган зохион байгуулдаг албыг дэлхий дахинд ийнхүү нэрлэдэг.

³ Орос хэлнээ “реабилитация преступника (ресоциализация, реадaptация)” гэж бичигддэг.

⁴ Насанд хүрэгчдэд болон хүнд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүйчүүдэд оногдуулсан ялын хувь хэмжээ.



Энэ улсад шүүх пробацацийн ялыг оногдуулах тохиолдолд ялтанд дараах үүргийг хүлээлгэдэг. Энэ нь:

- эрх зүйн журам (хэм хэмжээг)-ыг чанд сахиж, эрх зүйн эсрэг чиглэсэн зан байдал гаргахгүй байх

- шүүхийн дуудснаар шүүхэд хүрэлцэн ирэх

- амьдарч буй газар, ажлын байраа өөрчилсөн талаар шүүхэд болон пробацацийн албаны ажилтанд мэдэгдэх.

Түүнчлэн шүүх эдгээр ялтнуудад нэмэлт үүргүүдийг хүлээлгэж болдог. Тухайлбал: согтууруулах ундаа хэрэглэхээс татгалзах; зөвхөн эмчийн жор бичиж өгсөнөөр л мансууруулах эм бэлдмэлийг зохих хэмжээгээр хэрэглэх; зэвсэг эзэмших, хадгалах, авч явахаас түдгэлзэх; асран халамждаа байгаа хүмүүсээ тэжээн тэтгэх, анхаарал халамж тавих; 18 сараас дээшгүй хугацаанд 240 хүртэл цагын нийгэмд тустай ажил хийх болон нийтлэг хэм хэмжээний актаар тогтоосон бусад үүрэг, хязгаарлалт болно.

Тэгвэл пробацацийн алба ялын хэрэгжилтэд хяналт тавин гүйцэтгэлийг хангуулах хүрээнд дараах ажлын чиглэлээ нарийвчлан тодорхойлдог. Үүнд:

- гэмт этгээдээс бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх

- ялтан дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг гаргахгүй байхад чиглэсэн хөтөлбөр, хамтын харилцааны аргуудыг боловсруулах

- хамтын харилцааны хөтөлбөрийг хэрэгжүүлсэний дүнд гарч буй өөрчлөлтийн талаар шүүхэд тайлагнах

- Канадын эрх зүйн журамд заасан бусад чиглэлүүд тус тус болно.

Ер нь энэ улсад гэмт хэрэгтний харьцаанд гарсан шүүхийн шийтгэх тогтоол, ял шийтгэл, пробацацийн алба, түүний үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын, гэмт хэрэг үйлдэх шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэсэн олон талт ажил-арга хэмжээний хөтөлбөрийн талаарх зэрэг мэдээллүүд олон нийтэд нээлттэй байдаг.

Дараагийн онцлох зүйл нь шүүхийн шийтгэх тогтоолд анхлан дурьдагдсан пробацацийн нэмэлт нөхцөл-үүргүүд харьцангуй динамик шинжтэй ба шүүх гэмт хэрэгтний (ялтны) зан байдлын өөрчлөлтийг харгалзан тэдгээрийг өөрчлөх боломжтой. Тодруулбал ялтны ял эдэлж буй байдлын талаархи пробацацийн албаны ажилтан, прокуророос гаргасан саналыг шүүх судалж хүлээлгэсэн үүргийнхээ хугацааг өөрчилж, шийдвэрээ ялтанд мэдэгдэн баримт бичгийн хэлбэрээр албажуулдаг.

Мөн энэ улсад шүүхээс пробацацийн ялыг ялын бусад төрөлтэй, тухайлбал, торгууль, хорих ялтай хамтатган ноогдуулж болно.

Хэрвээ пробацацийн албаны ажилтнаас ялтан пробацацийн нөхцөлийг хэрхэн сахиж буй байдалд хяналт тавих, түүнийг нийгэмшүүлэхэд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг цаг хугацаанд нь авч явуулах, зан байдалд нь үнэлгээ дүгнэлт (цогц мониторинг хийх) өгөх, тайлан мэдээллийг шүүхэд болон холбогдох бусад байгууллагуудад өгөх үүрэг ноогддог бол

энэ тайлан мэдээг гаргах хугацаа, хэлбэрийг шүүх тодорхойлдог.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүх

харгалзан үр дүнтэй гэж үзвэл татварыг эрүүгийн хуульд заасан хувь хэмжээнээс дээшлүүлэн тогтоож болно.



пробацийн ялаас гадна торгууль, эд хөрөнгө хураах ял оногдуулж болно.

Торгуулийн ял оногдуулах шийдвэр (тогтоол)-ийг шүүх гаргахдаа торгуулийн хэмжээ, төлөх журам дараалал (ямар хувь хэмжээгээр), хугацаа (хэзээ)-г тодотгон зааж өгдөг. Мөн шүүх цаашид ялтны хүсэлтээр торгууль төлөх журмыг (дараалал) өөрчилж болох боловч торгуулийн хэмжээг өөрчилдөггүй.

Хохирогчид татвар төлөх явдлыг шүүхээс нэмэлт ялын хэлбэрээр ялтанд оногдуулж болох ба энэ нь торгуулийн ялын 30% эсвэл эрүүгийн хуулийн тодорхой гэмт хэргийн зүйл хэсэгт заасан ялгамжтай хувь хэмжээтэй. Мөн шүүх тухайн гэмт хэрэгтэн /ялтны/-ий эд хөрөнгийн байдлыг

Реституцийг шүүх прокурорын хүсэлт болон өөрийн дотоод итгэлээр оногдуулдаг. Ялын бусад төрлөөс түүний гол ялгаа нь эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон маш тодорхой хэлбэрүүдтэй.

Шүүх эд хөрөнгөд учирсан хохирлыг түүнийг сэргээн хэвийн байдалд оруулахад шаардлагатай мөнгөн хөрөнгийг гаргахаар үүрэг болгож болно. Мөн бусдын эрүүл мэндэд хохирол учруулсан тохиолдолд гэмт хэрэгтэн хохирогчийн эмчилгээний зардал, цалингийн зөрүү, үр хүүхдээ бусдаар халамжлуулахтай холбогдуулан гаргасан (боломжтой) зардлыг нөхөн төлдөг, хэрвээ

хохирогч шинэ баримт бичигтэй болсон бол түүнийг авахтай холбогдсон зардлыг төлнө.

Гуравдагч этгээд гэмт хэрэгтний хууль бус үйлдлийг мэдээгүй тохиолдолд оногдуулах реституци өөрийн онцлоготой. Тодруулбал: гэмт хэргийн дүнд ямар нэгэн эд хөрөнгө бусдад шилжсэн бөгөөд хүлээн авсан этгээд түүний хууль бус байдлыг мэдээгүй, мэдэх боломжгүй байсан бол хэдийгээр уг эд хөрөнгө хураагдан жинхэнэ эзэмшигч (өмчлөгч)-д шилжих боловч шүүх энэ үйл ажиллагаатай холбогдон үүссэн хохирлыг нөхөн төлөх үүргийг гэмт хэрэгтэнд хүлээлгэдэг.

Канадын эрүүгийн эрх зүйн үүднээс реституцийг торгууль болон эд хөрөнгө хураах ялаас илүүтэйгээр хэрэглэдэг ба түүний дараа л торгууль эсвэл эд хөрөнгө хураах ял оногдуулах асуудал шийдвэрлэгдэнэ.

Хоёроос илүүгүй жилийн хорих ялыг шүүхээс оногдуулсан тохиолдолд тэнсэн



харгалзах ял хэрэглэх боломжтой. Энэ ялыг ялтан оршин суугаа газартаа эдэлж түүний үйл ажиллагаанд пробацийн алба хяналт тогтоодог. Мөн энэ шийдвэр Канадын

эрүүгийн хуулийн 742-р зүйлийн 742.1 хэсгийн нөхцөл шаардлагад нийцсэн байх ёстой. Тодруулбал: бүх насаар нь хорих ял оногдуулах боломжтой болон терроризм, хүн хулгайлах, бусдыг хүчиндэх зэрэг гэмт хэрэг үйлдэгчдэд энэ ялыг хэрэглэдэггүй.

Шүүхээс тэнсэн харгалзах ял оногдуулсан тохиолдолд ялтан нийтлэг журмыг чанд сахиж, гэмт хэрэг зөрчил гаргахгүй байх, шүүхийн дуудснаар шүүхэд хүрэлцэн ирэх, ялтны үйл ажиллагаанд хяналт тавьж буй байгууллагатай хамтран ажиллах, өөртэйгөө холбогдсон мэдээлэл, оршин суугаа хаяг, ажлын газар өөрчлөгдсөн үед энэ талаар мэдэгдэх үүрэгтэй. Тэнсэн харгалзах ялын нэмэлт нөхцөл болгон шүүх согтууруулах ундаа, мансууруулах бодис, эм бэлдмэлийг хэрэглэх, зэвсэг эзэмшихийг хориглох, асран халамждаа байгаа хүмүүсийг тэжээн тэтгэх, эмчилгээнд хамрагдах үүргүүдийг хүлээлгэж болно. Мөн ялтанд хяналт тавих байгууллагын хүсэлтээр ял эдлэх нөхцөлийг өөрчилж болдог.

Канадад насанд хүрээгүйчүүдийн эрүүгийн шүүн таслах үйл ажиллагаа насанд хүрэгчдийн шүүх хуралдаанаас тусдаа явагддаг.

2004 оны 04-р сарын 01-ээс хүүхэд, залуучуудад шаардлагатай үйлчилгээг үзүүлэх асуудал хариуцсан яам байгуулагдсан ба тэрээр энэ хүмүүст туслах хөтөлбөрийг, мөн насанд хүрээгүйчүүдийн харьцаанд авсан пробацийн шүүхийн тогтоолын гүйцэтгэлийг хариуцдаг. Өнөөдөр Канадад пробацийн мэргэжилтнүүд нь Хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн яамны төрийн албан хаагчид болно.

Ер нь пробаци өсвөр үеийнхний харьцаанд хэрэглэгддэг маш үр дүнтэй арга хэмжээнд тооцогддог. Онтарио засаг захиргааны нэгжийн пробацийн албаны мэдээнээс үзвэл шүүн таслагдсадын 63% нь тэнсэн харгалзах ял, 28% нь нийгэмд тустай ажилд хамрагдах, 9 орчим хувь нь хаалттай ("засан хүмүүжүүлэх") байгууллагад хорих ял эдлэдэг.

Пробацийн ялын хугацаа нь 12, түүнээс доош сар болно. Үйлдсэн хэрэг, гэмт хэрэгтний хувийн байдлаас шалтгаалан пробацийн нөхцөлүүдийг шүүх өөр өөрөөр тогтоодог. Тухайлбал: насанд хүрээгүй ялтныг тогтоосон хугацаанд пробацийн албаны өөрийн мэргэжилтэнд шалгуулахаар ирэхийг, гэр бүлтэйгээ эсвэл өөр тогтоосон газарт амьдрахыг, ажилд орохыг, сургуульдаа эргэн суралцахыг, гадагшаа гарахгүй байх цагийг тогтоох, тодорхой хүмүүстэй уулзахгүй байх, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхгүй байх үүргүүдийг хүлээлгэж болно. Өнөөдөр Онтарио засаг захиргааны нэгжийн 65 орчим пробацийн нэгжид 800 гаруй мэргэжилтэн-алба хаагч ажиллаж байна.

Төгсгөлд нь тэмдэглэхэд энэ улсын шүүхээс ял оногдуулахад шүүгчийн үзэмж-дотоод итгэл онцгой үүрэгтэй ба тэрээр гэмт хэрэгтэн бие хүнд тохирсон тодорхой ял болон түүний (нэмэлт) тусгайлсан үүргүүдийг хүлээлгэдэг онцлогтой.



КРЫМОВ
АЛЕКСАНДР
АЛЕКСАНДРОВИЧ

Кандидат
юридических наук,
доцент, генерал-майор
внутренней службы,
начальник Академии
ФСИН России

ИЗУЧЕНИЕ МНЕНИЯ СОТРУДНИКОВ УЧРЕЖДЕНИЙ И ОРГАНОВ, ИСПОЛНЯЮЩИХ НАКАЗАНИЕ, О НЕОБХОДИМОСТИ УСИЛЕНИЯ УГОЛОВНО- ПРОЦЕССУАЛЬНОГО РЕГУЛИРОВАНИЯ ДЕЯТЕЛЬНОСТИ УГОЛОВНО- ИСПОЛНИТЕЛЬНОЙ СИСТЕМЫ

В процессе предупреждения, пресечения, выявления и раскрытия преступлений сотрудники уголовно-исполнительной системы (УИС) занимаются не только исполнением уголовных наказаний, но и уголовно-процессуальной деятельностью⁵.

К сожалению, этот вид деятельности сотрудников учреждений и

⁵ См.: Пудаков Е.Р. Уголовно-процессуальная деятельность органов и учреждений уголовно-исполнительной системы России: Автореф. дис. ... канд. юрид. наук. – Владимир, 2008; Крымов А.А., Спиридонова Ю.Н. Вопросы регламентации уголовно-процессуальной деятельности в уголовно-исполнительной системе Российской Федерации // Особенности уголовно-процессуальной деятельности органов и учреждений ФСИН России: сборник материалов международной научно-практической конференции (Вологда, 25 ноября 2010 г.). – Вологда: ВИПЭ ФСИН России, 2011. С. 12-17; Ухова Е.В., Колпакова Л.А. Совершенствование уголовно-процессуальной деятельности органов и учреждений уголовно-исполнительной системы в стадии возбуждения уголовного дела // Вестник института: преступление, наказание, исправление. 2012. № 4. С. 33-38; и др.